



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 542

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Хөрөнгө шилжүүлэх тухай” 30, 31 дүгээр тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Гурванзагал, Матад сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй хавсралтад дурдсан нийт 178,566,413.00 (нэг зуун далан найман сая таван зуун жаран зургаан мянга дөрвөн зуун арван гурав) төгрөгийн балансын үнэ, 83,292,730.00 (наян гурван сая хоёр зуун ерэн хоёр мянга долоон зуун гуч) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээн авах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002507

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
542 дугаар тогтоолын хавсралт

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл үнэ /төгрөг/
1	0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	2014	м	600	18,917,295.00	3,468,171.00	15,449,124.00
2	15/0.4 кВ-ын дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам	2014	м	2700	159,649,118.00	79,824,559.00	79,824,559.00
	Нийт үнэ			3300	178,566,413.00 (нэг зуун далан найман сая таван зуун жаран зургаан мянга дөрвөн зуун арван гурав)	83,292,730.00 (наян гурван сая хоёр зуун ерэн хоёр мянга долоон зуун гуч)	95,273,683.00 (ерэн таван сая хоёр зуун далан гурван мянга зургаан зуун наян гурав)